



СЭЛЭНГЭ АЙМАГ
ЦАГААННУУР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 58

Хуурч

2022 оны мал, амьтны шимэгчтэх
өвчинөөс сэргийлэх төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт, Сумын Засаг даргын 2022 оны 103 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Сумын мал эмнэлгийн үйлчилгээний нэгж бүрээр мал, амьтныг шимэгчтэх өвчинөөс урьдчилан болон эмчлэн сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт 1, угаалганд хамрагдах мал, амьтны төлөвлөгөөг хавсралт 2, туулгантанд хамрагдах мал, амьтны төлөвлөгөөг хавсралт 3, боловсруулалтанд хамрагдах мал, амьтны төлөвлөгөөг хавсралт 4-өөр тус тус баталсугай.

Хоёр. Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган хяналт тавьж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг сумын Мал эмнэлгийн тасгийн дарга (М.Алтаннавч)-д, мал, амьтныг шимэгчтэх өвчинөөс сэргийлэх ажлыг зохион байгуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга (Ц.Баянбаатар) нарт тус тус үүрэг болгосугай.



1320030002 СЭТ0038 3762629